


Улаанбаатар хот дахь ХБИ-ийн нийгмийн оролцоог дэмжих төсөл

Мэдээллийн эмхэтгэл № 6 (2018 он 1-р сар)

“Хөгжлийн бэрхшээлтэй манлайлагч бэлтгэх” Япон дахь сургалтын тусгай дугаар

Нүдний харцаараа удирдах боломжтой компьютер!

12-р сарын 18-ны өдрийн үдээс хойш Токио хотын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ИТ-ийн тусламж дэмжлэг үзүүлэх төвийн үйл ажиллагаатай танилцлаа. Тус төвийн үзүүлэнгийн танхимд маш олон төрлийн тоног төхөөрөмж байсан бөгөөд тэдгээрийг сургалтанд оролцогчид нэг бүрчлэн сонирхон үзэж байлаа. Тухайлбал нэг гараараа хэрэглэх боломжтой кийборд, хацраа хүргээд ашиглах боломжтой хулгана зэрэг байсан ба хамгийн ихээр сонирхол татсан нь компьютерт тусгай мэдрэгч, аппликейшн суулгаад дэлгэц рүү нь нүдээрээ хараад л харцаараа удирдаж ашиглах боломжтой технологи байлаа. Энэхүү технологийг ашигласнаар биеэ хөдөлгөх боломжгүй иргэд компьютер ашиглах боломжтой болох юм. Мөн тус төвд Токио хотоос хол газарт амьдардаг ХБИ ажилладаг. Нийгата мужид амьдардаг ноён Сайто микрофон, камер суурилуулсан роботын тусламжтайгаар төвийн ажилчидтай ярилцаж, хуралд оролцдог байна. Скайп /Skype/-аас ялгаатай нь ноён Сайто өөрийн хүслээр камераа удирдах боломжтой. Өөрийн харахыг хүссэн чиг, мөн харах түвшнийхээ өндөр намыг ч гэсэн тохируулах боломжтой тул яг л ажилчидтай хамт байгаа мэт сэтгэгдэл төрүүлж байлаа. “Сүүлийн үед манай төвөөр аливаа зүйлийг ойлгох, таньж мэдэх, тогтооход хүндрэлтэй хүмүүс үйлчлүүлэх нь ихэсч байна.” хэмээн төвийн дарга хатагтай Хоригомэ өгүүлж байлаа. Компьютерээс ухаалаг утасны хэрэглээ рүү хувьсан өөрчлөгдөж буй техник технологитой адилаар хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлага ч гэсэн өөрчлөгдөж байгаа бололтой. Хэрэглэгч нэг бүрийн хэрэгцээнд нийцсэн тусламж дэмжлэг үзүүлдэг тус төвийн үйл ажиллагаатай танилцсандаа баяртай байна.



Нүдний харцаараа PC ашиглаж байгаа нь

Гүнма мужийн бага сургуулиар зочиллоо

12-р сарын 19-ний өдөр Шинзатогийн төв бага сургуульд зохион байгуулагдах Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт (DET)-д ажиглагчаар оролцох зорилгоор Гүнма мужийн Кирюү хотод очлоо. Энэ удаагийн сургалтанд оролцож буй хүмүүсийн 5 нь DET сургалтын сургагч багш учраас “Японы туршлага, үйл ажиллагаанаас суралцах” сайхан боломж тохиосон гэдэгт итгэлтэй байна. Мөн тус өдөр сургалтанд оролцогчид бүгд дээл өмсөж очсон.



(DET сургалтын явц)

Бага сургуулийн 6-р ангийн 60 сурагч оролцсон DET сургалтыг Гүнма мужийн 3 сургагч багш чиглүүлж явуулсан. Тэдний зохион байгуулсан сургалтаас бага насны хүүхдүүдэд хэрхэн ойлгомжтой, хөгжилтэй байдлаар сургалт явуулах олон шинэ санааг олж авсан гэдэгт итгэлтэй байна.

Сургалтын дараах санал бодол солилцох уулзалтын үеэр асуусан “Сургуульд зохион байгуулсан DET сургалтаас өнөөг хүртэл ямар үр дүн гарсан бэ?” гэсэн асуултанд сургуулийн захирал багш, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн ээжүүд доорх хариултыг өглөө. “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд хандах багш, сурагчдын хандлага өөрчлөгдсөн” гэх бодитой үр дүнгийн талаар сонсоод сургалтанд оролцогчид хүүхдүүд багаасаа хөгжлийн бэрхшээлийн талаар зөв ойлголттой болох нь чухал юм байна гэдгийг улам илүү ойлголоо.

Их сургуулийн амьдрал



(DPUB төслийн ахлах зөвлөх Чиба Хисао)

Австралийн Воллонгонг их сургууль (University of Wollongong)-ийн Олон улсын харилцааны сургуульд урам зоригтойгоор элсэж орсон би хичээлийн эхний улирал шоконд орлоо. Яагаад гэвэл профессор багш нарынхаа англи хэлийг сайн ойлгохгүй байсан юм. Тэр үед англи хэлний сургуульд хичээл зааж байсан багш нар маань “стандарт” англи хэлээр ярьж байсныг ойлгосон юм. Их сургуулийн багш нарын хувьд өөр өөр улс үндэстний хүмүүс байдаг учраас дуудлага нь ч ялгаатай байлаа. Дээр нь хичээлийн үеэр мэргэжлийн үг хэллэг их хэрэглэгддэг учраас сайн ойлгохгүй байсан. Ийм байдалтай байх юм бол ер нь л “болохгүй” юм байна гэж бодоод хариуцсан багштайгаа зөвлөлдөн туслах оюутантай болохоор шийдлээ. Мөн өөрийгөө мэргэжлийн мэдлэг ойлголт муутай гэдгээ тайлбарлалат багш маань “Тэгвэл 1 жил хагас сурвал зүгээр юм биш үү?” гэж хэлээд суралцах хугацааг маань уртасгаад өгчихөв. Хичээлээ бүрэн гүйцэт ойлгож чадахгүй байсан би эхэн үедээ “сайн зүйл боллоо” хэмээн баяртай байсан хэдий ч суралцах хугацаагаа ийм хялбархан уртасгах боломжтой Австралийг бага зэрэг гайхаж байлаа. Гэхдээ ингэсний хүчинд эхний улирлынхаа 1 хичээл дээр унасан боловч 2 хичээл дээр тэнцэж, 2-р улирлынхаа бүх хичээл дээр сайн дүнтэй тэнцэж, 3-р улиралд ч гэсэн онц сайн дүнтэй суралцаж сургуулиа төгсөж чадлаа. Одоо бодохоор энэ бүхэн багшийн маань шийдвэрийн ач тус байжээ гэж их талархдаг. Төгсөлт ойртоод ирэхээр дараа нь ажилд орох асуудал гарч ирлээ. Олон улсын харилцаагаар магистр хамгааллаа гээд НҮБ-д амархан ажилд орно гэсэн үг биш шүү дээ... Удаан бодсоны эцэст эхлээд НҮБ-д дадлага хийх хүсэлт гаргахаар боллоо. (Үргэлжлэлийг дараагийн дугаарт...)



JICA DPUB фэйсбүүк хуудсанд **LIKE** дарж нэгдээрэй!!

Төслийн фэйсбүүк хуудсанд LIKE дарсан нийт хүний тоо **1022** болж, маш олон хүнд төслийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл хүрэх боллоо. Цаашид ч гэсэн олон сонирхолтой мэдээллүүдийг та бүхэнд хүргэхийн тулд хичээн ажиллах болно.

Монголд DET сургалт амжилттай зохион байгуулагдаж байна



(DET сургалт явуулж буй сургагч багш)

12-р сарын 22-ны өдөр буюу сургалтын хамгийн сүүлийн өдрийн хичээл сэдэв “DET давтлага сургалт” байлаа. Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт (DET)-ын 5 сургагч багш яг 1 жилийн дараа DET сургалтын зааварлагч Күно багштай дахин уулзаж байгаадаа маш баяртай байсан юм. Тэд багшийн өмнө DET сургалт хийж үзүүлсэн болохоор сандраад “Жирийн үеийнхээсээ арай өөрөөр ярьчихлаа...” хэмээн ярьж байлаа. Күно багш сургагч багш нарт хандан “Дасгал ажил тус бүрийн зорилгыг ойлгомжтой, тодорхой тайлбарлах хэрэгтэй. Дасгал ажлын үед оролцогчид юуг ойлгож, юуг олж харах ёстой вэ?” гэх мэтээр зааварчилгаа өгсөн төдийгүй “Монголд DET сургалт дэлхийн бусад орнуудаас илүү амжилттай зохион байгуулагдаж байна. Та бүхэн маш амжилттай ажиллаж байна.” хэмээн урмын үг хэлж байлаа. Сургалтын дараа Японы DET Форум байгууллагын ажилчидтай санал бодол солилцсон ба DET Форумын гүйцэтгэх нарийн бичиг Нагашима, тэргүүлэгч Күсүмэ нар байгууллагынхаа үйл ажиллагаа, сургагч багш нарыг хэрхэн бэлтгэж буй талаараа танилцууллаа. Мөн Японд ч гэсэн Монголтой адил сургалтын үйл ажиллагаанд идэвхтэй хамрагддаггүй сургагч багш нар байдаг гэж ярьж байсан. Монголын сургагч багш нар “DET сургалтыг сургагч багш нар өөрсдөө бие дааж явуулах тохиолдолд орлогынхоо тодорхой хувийг форумд өгдөг үү?” гэх мэт олон асуулт асууж харилцан ярилцсан. “DET Форум Монгол” ТББ байгуулагдаад удаагүй ч гэсэн цаашид Японы туршлагаас суралцан үйл ажиллагаагаа улам өргөжүүлэн ажиллана гэдэгт итгэлтэй байна.

Өөрөө сонгох, өөрөө шийдэх бие даах амьдрал



(лекцийн үеэр)

12-р сарын 21-ний өглөө сургалтын багийнхан Токио хотын Хачиожи хотод байдаг Human Care нийгэмлэг дээр очин, Японы Бие даан амьдрах төвийг үүсгэн байгуулсан анхдагчдын нэг Наканиши багшийн лекцийг сонслоо. Лекцийн өмнө сургалтанд оролцогчид өөрсдийгөө танилцуулсан бөгөөд Наканиши багш тэдний ажил мэргэжил зэргийн талаар сонирхон асууж байсан. Ялангуяа хамгийн хүнд хэлбэрийн бэрхшээлтэй оролцогчоос олон асуулт асууж байлаа. Монголын Бие даан амьдрах төвд ажилладаг оролцогчид “Японы Бие даан амьдрах төвийн эцэг” гэгддэг Наканиши багштай уулзсандаа ихэд баяртай байсан юм. Японд анх Бие даан амьдрах төв үүсэж эхэлсэн тухайн үед хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сэргээн засалтынхаа хугацааг дуусгасны дараа асрамжийн газарт очих эсвэл эцэг эхийнхээ асаргаанд орохоос өөр сонголт байхгүй байжээ. Өөрөөр хэлбэл өөрийнхөө амьдралыг өөрөө шийдэх боломжгүй байсан. Мөн Наканиши багш цаашид Монголд Бие даан амьдрах ойлголтыг түгээн дэлгэрүүлэхийн тулд Туслах үйлчилгээний системийг бий болгох нь чухал хэмээн өгүүлж байсан. Тус лекцээс “Зөвхөн хувцсаа өмсөхийн тулд 2 цаг зарцуулах бус, хүний туслалцаа аваад өөрийн хүслээр амьдрах хэрэгтэй” гэх мэт хэрхэн бие даан амьдрах талаар суралцлаа. Бие даан амьдрах төвийнхөн юуны өмнө хамгийн хүнд хэлбэрийн бэрхшээлтэй иргэнийг бие даалгах хэрэгтэй. Тэгвэл өөр бусад бүх бэрхшээлтэй иргэдэд үйлчилгээ үзүүлэх боломжтой болно гэсэн багшийн ярианаас олон шинэ зүйлийг олж авлаа.

Зүрхэн тэмдэгтийн холбоо

Оюуны бэрхшээл, хөгжлийн хоцрогдол гээд харахад анзаарагдахгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ямар хэлбэрээр туслалцаа үзүүлвэл хамгийн тохиромжтой байх бол оо? Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт (DET)-ын дэмжигчээр ажилладаг хатагтай Арикэ тэргэнцэр, цагаан таяг хэрэглэдэг хүмүүсээс ялгаатай, харахад анзаарагдахгүй ХБИ-ийг яавал хүмүүст зөвөөр ойлгуулах вэ гэж бодсоны эцэст “зүрхэн тэмдэг”-ийг ашиглах болжээ. Тус тэмдэг нь 2 төрөлтэй бөгөөд бичигтэйг нь ХБИ өөрсдөө, бичиггүйг нь тэднийг дэмжигч хүмүүс зүүдэг байна. Өөрөөр хэлбэл нэг нь “харахад анзаарагдахгүй хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй”, нөгөө нь “дэмжин ажиллана” гэсэн утгыг илэрхийлдэг. Тэргэнцэртэй иргэдийн лого, улаан тууз шиг бүх хүмүүс хараад л ойлгох тэмдэгтэй болсноор эргэн тойрных нь хүмүүсийн ойлголт ч гэсэн зэрэгээр өөрчлөгдөж байгаа аж. Хатагтай Арикэгийн хүүгийнх нь зурсан зүрхний зурагтай тэмдгийг Япон орны өнцөг булан бүрээс захиалан хэрэглэх хүмүүсийн тоо улам илүү нэмэгдсээр байна.

(зүрхэн тэмдэгт)

Сайн манлайлагч болж, улам их амжилт гаргахыг хүсье

Сургалтын хамгийн сүүлийн өдөр буюу 12-р сарын 26-ны өдөр сургалтанд оролцогчид монгол дээлээ өмсөж, 2 долоо хоногийн хугацаанд юу сурч мэдсэн тухайгаа холбогдох хүмүүст тайлагналаа. Өмнөх өдрийн сургуулилтын үеэр нэг нэгнийхээ илтгэлийг сонсож, харилцан санал солилцсон учраас тайлангийн агуулга нь улам илүү сайжирсан байсан. Тус тайлангийн хуралд хичээл заасан багш нарын төлөөлөл оролцсон бөгөөд хөдөлмөр эрхлэлт, дэд бүтэц, мэдээллийн хүртээмж гээд Японы яг ямар зүйлээс нь суралцсан байна вэ гэдгийг чих тавин сонсож байлаа. Тэмүүлэнгийн “Галт тэргэнд суух үед буудлын ажилчид зөөврийн налуу зам тавьж өгдөг нь сайхан санагдсан.” гэх яриаг сонсоод Японы DPI байгууллагын ноён Сай “Тадны орнуудад тэргэнцэртэй иргэн бусдаас тусламж авалгүйгээр өөрөө галт тэргэнд сууж буух боломжтой байдаг. Тийм болохоор цаашид Монголд галт тэрэг, метро тавих бол эхнээс нь хүн бүрт хүртээмжтэй байхаар хийх хэрэгтэй” хэмээн зөвлөгөө өгсөн. Мөн DET Форумын ноён Күсүмэ “Одоо ч гэсэн Японы хөдөө орон нутагт дэд бүтцийн хүртээмж хангалтгүй байгаа” хэмээн бодит нөхцөл байдлын талаар ярьж байлаа. Тус тайлангийн хуралд Human Care нийгэмлэгийн ажилтан хатагтай Үчияма өөрийн туслах ажилтантайгаа хамт оролцсон бөгөөд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэн өөрөө сонгож, өөрөө шийднэ” гэсэн бие даах амьдралын ухагдахууныг сургалтанд оролцогчид маш сайн ойлгосон байгааг хараад талархал илэрхийлж байсан. Мөн тэдэнд хандан “Сайн манлайлагч болж, улам их амжилт гаргахыг хүсье” хэмээн урмын үг хэллээ.



(Төгсгөлтийн ёслолын үеэр)

Хаяг: Монгол улс, Улаанбаатар-15160, Нэгдсэн үндэстний гудамж-5, Засгийн газрын 2-р байр, ХНХЯ

Фэйсбүүк хуудас: <https://www.facebook.com/jicadpub>

Цахим хуудас: <https://www.jica.go.jp/project/mongolia/015/index.html>

И-мэйл: dpub.jica@gmail.com